



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

117 /117/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.20

ҮЙЛ ЯВДАЛ

ДАЙЧДАА АЛДАРШУУЛСАН ДУУНЫ КЛИП УДАХГҮЙ МЭНДЭЛНЭ



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулан ЦДБЭЧ, ЗХЖШ-ын Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжим, Төрийн соёрхолт "Харанга"

хамтлаг хамтран "Монгол Улсынхаа төлөө зүтгээ" дууг бүтээсэн бөгөөд тус бүтээлийн клипны зураг авалт төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Дайчин эрсийн сүлд хийморь,

Зэвсэгт хүчний сүр жавхааг аялгуу эгшигэнд өлгийдөн үе үеийн баатар эрсдээ зориулсан энэхүү бүтээлийг олон зуун уран бүтээлчид сэтгэл нэгдэн туурвиж байгаа юм. Тун удахгүй клип нь мэндлэх

"Монгол Улсынхаа төлөө зүтгээ" уран бүтээл тэргүүндээ соёмбоо залсан, эх орноо аминаасаа ч илүү хайрласан аавын хүү, ээжийн охидын омогшлын дуулал байх нь дамжиггүй юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 19 | 6 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 29 | 22 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|-------|---------|---------|
| USD | 2.848.0 | 2.851.0 |
| EUR | 3.365.0 | 3.373.0 |
| CNY | 440.0 | 441.3 |
| RUB | 38.00 | 39.10 |
| JPY | 25.68 | 26.12 |
| KRW | 2.39 | 2.48 |

ЗУРХАЙ

2021.08.20 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 13/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН НЭГ ЦАГААН ЦАГААЧИН ХУЛГАНА ӨДӨР

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙГЭЭР СОНИН САЙХАН ЮУТАЙ ...



хэлэлцүүлээ. Үүний дараа Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс Монгол судлалын Америк төвтэй хамтран зохион байгуулсан "Халхын голын дайны өв, түүний хадгалалт хамгаалалт" сэдэвт цахим хэлэлцүүлэгт оролцлоо.

Urtech компани нь "Виртуал өв соёл" төслийг санаачлан Соёлын яамны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй 10 музейг виртуалаар хийхээр төлвөлж Монгол цэргийн музей сонгосон юм. Энэ ажлын хүрээнд Монгол цэргийн музей, Г.К.Жуковын дурсгалын музей дээр 25 цэгт зураг авалт хийгдэн онцлох үзэмрүүдийг аудио болон видеоогоор монгол-англи хэл дээр танилцуулахаар бэлтгэж байгаа ажээ. Түүнчлэн Монголын соёлын

өв, музей, дурсгалт газруудыг Монголдоо төдийгүй олон улсад VRNOMADIC.COM платформуор дамжуулан сурталчлан таниулах, дижитал орчинд хадгалан үлдэх өвлүүлэх зорилготой юм.

Дараагийн дугаарт сан хөмрөгийн үзэмр, эд зүйлийг төрөлжүүлэн хадгалалтын зохистой орчин бүрдүүлж, чийг дулааны горимыг нь мөрдөн, байршлыг тодорхой болгож эмх цэгцгийг сайжруулах нь музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын хамгийн чухал үндсэн ажил байдаг. Иймд музей нь өвөл сургуулийн бэлтгэл ажлыг ханган 7-8 дугаар сард сан хөмрөг дахь эд өлгийн зүйлийн хадгалалтын байдалд үзлэг шалгалт хийж, бүртгэлийг тулгах, засч сайжруулах ажлыг явууллаа.

БХЯ-ны ШУТЗ-өөс дэмжигдсэн "1939, 1945 оны дайнд оролцсон ахмад дайчдын судалгаа"-ны төсөл хэрэгжүүлэх багийн төслийн удирдагч БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Содномцог, Монгол цэргийн музейн захирал, хурандаа Д.Ганзориг, төслийн зөвлөх БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.Сүхбаатар, БХТА-ын орлогч дарга, дэд хурандаа Ж.Гантулга, төслийн зохицуулагч МСЭШСХ-ийн албаны дарга, ЭША-тан А.Ганганчимэг, ЭША-тан, түүхч Ж.Одонтуяа нар анхны уулзалтыг амжилттай зохион байгуулж, ажил үүргийн хуваарийг гарган боловсруулан 2022 оны нэгдүгээр улиралд багтаан анхны

ботийг гаргахаар судалгааны ажлаа хийж байна.

Мөн Соёлын сайдын тушаалаар "Музейн орчны аюулгүй байдлын стандарт", "Сан хөмрөгийн аюулгүй байдлын стандарт" боловсруулах дэд ажлын хэсэгт музейн мэргэжлийн албан хаагчид томилогдон ажиллав.

Нүүдлийн Соёл иргэншлийг судлах Олон улсын хүрээлэн, Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Өндөр Гэгээн ба өв уламжлал" цахим эрдэм шинжилгээний хуралд "Богд хаан шар ордон руугаа заларсан нь" монгол зургийн талаар музейн лабораторийн эрхлэгч-археологич Э.Түвшин илтгэл амжилттай



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|-----------------------------------|---------------------------|----------------------|
| НИЙТ БҮРТГЭГДСЭН 189.407 +1875 | ЭДГЭРСЭН 173.696 +1672 | НАС БАРСАН 891 +2 |
|-----------------------------------|---------------------------|----------------------|

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| | | |
|-----------------------------|-------------------------------|----------------------|
| НИЙТ БАТЛАГДСАН 4402 +80 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 163 +9 | ЭДГЭРСЭН 4153 +10 |
|-----------------------------|-------------------------------|----------------------|

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

| |
|--------------------------------|
| Тохиолдол Нийт: 210,791,501 |
| Эдгэрсэн Нийт: 188,726,483 |
| Нас барсан Нийт: 4,416,169 |



Эл өдөр баян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одоосод зүүн ургааш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.



ИРЭХ АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД ХАНГАЙН УУЛСААР ЦАС ОРНО



2021 оны 8 дугаар сарын 20-ноос 8 дугаар сарын 23-ныг хүртэлх цаг агаарын урьдчилсан төлөв: Наймдугаар 20-нд баруун аймгуудын нутгийн хойд хэсэг, зүүн аймгуудын нутгийн зарим газраар, 21-нд баруун болон зүүн аймгуудын нутгийн хойд, төвийн аймгуудын нутгийн баруун хэсгээр, 22-нд нутгийн хойд хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи 21-нд нутгийн баруун хэсгээр, 22-нд нутгийн зарим газраар секундэд 13-15 метр бусад хугацаанд нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир

орчим, Завхан голын эх, Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 0-5, өдөртөө 12-17, говийн бүс нутгаар шөнөдөө 14-19, өдөртөө 24-29 хэм бусад нутгаар шөнөдөө 6-11, өдөртөө 18-23 хэм дулаан байна.

Хугацааны сүүлчээр шөнөдөө нутгийн хойд хэсгээр цочир хүйтэрч болзошгүй.

Цочир хүйтрэл гэж юу вэ?

Ургамал ургалтын улиралд буюу агаарын температур эерэг утгатай байх үед агаарт 2 метрийн түвшинд эсвэл хөрсний гадарга дээр температур 00 буюу түүнээс бага хасах утгатай болж буурахыг цочир

хүйтрэл гэнэ.

Цочир хүйтрэлийг "хяруу унах", "хяруунд тариа цохиулах", "гэнэтийн хүйтрэл" гэх мэтээр ярих, бичих нь бий. Хүйтэн агаар 100-аас бага температуртай тухайн газар температуртай ирэх хүйтэн агаарын цөмрөл эсвэл газрын гадарга цацрагийн замаар дулаанаа их хэмжээгээр туяаруулан алдаж хөрөх зэрэг шалтгаанаас цочир хүйтрэл болох нөхцөл бүрддэг байна.

Манай орны уулархаг нутгаар намар цочир хүйтрэл эрт эхэлдэг. Далайн түвшнээс 2000 м буюу түүнээс дээш өндөр өргөгдсөн уулст намрын цочир хүйтрэл 8 дугаар сарын 20-ноос өмнө эхэлдэг байна.

ДООРХ ЗӨВЛӨМЖИЙГ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГЛӨӨ



2021-2022 хичээлийн жил 9 дүгээр сарын 1-нд эхлэхтэй холбоотойгоор бэлтгэл ажлыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас шалгаж байна.

Шалгалт 9 дүгээр сарын 17-ныг хүртэл үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд боловсролын байгууллагууд дараах зөвлөмжийг өгч ажиллаж байгааг НМХГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга Д.Цэнд-Аюуш танилцуулав. Тэр бээр "Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй боловсролын 959 байгууллага байгаагийн 40 орчим хувь буюу Сургуулийн өмнөх боловсролын 226, Ерөнхий боловсролын 114 сургууль, Дээд боловсролын 25 байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн зургаан байгууллага

Цэцэрлэгүүдийг хүнсээр хангахад таван байгууллага нийт 406 аж ахуйн нэгжийн үйл

ажиллагааг шалгаж байна. Хяналт шалгалтын явцад зөвлөн тусалж, сургалтын байгууллагууд дараах зөвлөмжийг өглөө.

Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сургалтын байгууллагын удирдлагууд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг гаргаж, дотоод хяналтын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, Б а й г у у л л а г ы н х а а ойролцоох нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх Хичээл сургалтын болон дотуур байранд ариутгал халдваргүйтгэлээс гадна мэрэгч амьтан, шавжийн устгал хийлгэх, Д а р х л а а ж у у л а л т ы н болон шинжилгээний цэгийн зориулалтаар ашиглагдсан сургууль, цэцэрлэгүүд ариутгал, халдваргүйтгэл хийлгэхдээ онцгой анхаарах,

Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад багш ажилтан, суралцагч, дотуур

байрны хүүхдээс сэжигтэй тохиолдол илэрсэн үед эмнэлгийн байгууллагад шилжүүлэх хүртэл хугацаанд тусгаарлах байрыг бэлтгэх,

Цэвэрлэгээ үйлчилгээний бодис, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, Анги танхим, дадлагын газар, хоолны газарт сандал хоорондын зайг 1.5 метрээс доошгүй байлгах, Нэг ангид 20-оос илүүгүй хүүхэд суралцуулах, Дотуур байранд нэг оронд ногдох талбайн хэмжээг 4 м.кв-аас багагүй, ор хоорондын зайг 1.5 метр байхаар зохион байгуулах,

Боловсрол, сургалтын байгууллагад бөөгнөрөл үүсэхгүй байхаар орох, гарах урсгалыг зохион байгуулах, Анги танхимд дулааны улиралд цаг тутамд 15 минутын турш энгийн салхивчийг нээж агаар сэлгэх, өвлийн цагт механик агааржуулалтын системийг тогтмол ажиллуулах зэрэг зөвлөмжийг өгсөн" гэв.

АРАВДУГААР САРЫН 1-НИЙ ДОТОР ТОРГУУЛИА ТӨЛӨХГҮЙ БОЛ ӨРШӨӨЛИЙН ХУУЛЬД ХАМРАГДАХГҮЙ



Тулгар төр байгуулагдсаны 2230, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн

этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтгүүлэх өршөөл үзүүлэх тухай хуулийг УИХ батлан гаргасан. Хууль 2021 оны 7

дугаар сарын 6-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн билээ. Уг хуульд зааснаар 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 00:00 цагаас өмнө Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор торгох шийтгэлийн төлбөрийн 50 хувийг төлсөн бол үлдсэн хувийг өршөөн чөлөөлөх юм.

Хэрэв 10 дугаар сарын 1-ний дотор торгуулийн 50 хувийг төлж барагдуулаагүй тохиолдолд өршөөлд хамрагдахгүй гэдгийг Тээврийн цагдаагийн албанаас анхаарууллаа.

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТ СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ ИЛЭРВЭЛ ШИНЖ ТЭМДГЭЭС ХАМААРЧ ГЭР ЛҮҮ НЬ БУЦААХ, ЭСВЭЛ ЭМНЭЛЭГ РҮҮ ШИЛЖҮҮЛНЭ



ХЭСҮТ-ийн Тандалт эрхэлсэн дэд захирал Ж.Байгалмаа цэцэрлэг, сургуульд "Ковид-19"-ийн тохиолдол илэрвэл хэрхэн ажиллах талаар зөвлөмж өглөө.

Тэр бээр "Цар тахлын үед эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбарын хамтын ажиллагаа нэн чухал ач холбогдолтой. Тэр дундаа сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлж байгаа энэ үед эрүүл мэнд, боловсролын салбар болон аймаг орон нутгийн засаг захиргааны

байгууллагууд, эцэг эхчүүдийн хамтран ажиллах хэрэгтэй. Халдварын тархалтаас хамааран энэ жил сургууль, цэцэрлэгийг бүтэн танхимаар болон цахимаар гэж хосолсон хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тодруулбал, халдвар алаг цоог бүртгэгдсэн болон огт халдвар бүртгэгдээгүй аймаг, сумдад танхимаар бүрэн хичээллэх боломжтой. Харин хүн амын дунд халдвар голомтолж тархсан үед танхим болон цахим хэлбэрийг хослуулж 5/9-ийн зарчмаар

хичээллүүлэхээр болсон.

Танхимаар хичээллэх үед сургууль, цэцэрлэгт сэжигтэй тохиолдол илэрсэн эсвэл халдварын тохиолдол батлагдсан үед сургууль, цэцэрлэгийн багш, нийгмийн ажилтнууд эрүүл мэндийн байгууллага хамтран батлагдсан заавар журмыг мөрдөж ажиллана. Тухайлбал, хүүхдийн шинж тэмдэг хөнгөн байгаа үед эцэг эхэд нь мэдэгдэж гэр лүү нь буцаах, хүнд тохиолдолд эмчид мэдэгдэж, эрүүл мэндийн байгууллага руу шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай. Мөн өглөө бүр хүүхдүүдийг сургууль, цэцэрлэг дээрээ ирэхэд халууныг нь хэмжиж, ирцийн бүртгэл хийх байдлаар өдөр тутмын тандалтыг зохион байгуулах хэрэгтэй. Харин эцэг, эхчүүд хүүхдэдээ амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн, халуурсан, хоолой өвдсөн, суулгаж гүйлгэх шинж тэмдэг илэрсэн үед ангийн багш болон сургуулийн холбогдох шатны хүмүүст мэдэгдэж, сургууль, цэцэрлэгт нь явуулахгүй байх шаардлагатайг хэлье" гэв.

"СПУТНИК V", "MODERNA"-ГИЙН ВАКЦИНЫ ХОСЛОЛ ДАРХЛААНЫ ХАРИУ УРВАЛЫГ НЭМЭГДҮҮЛЖЭЭ

Оросын "Спутник V" вакцины эхний тунг Америкийн "Moderna" компанийн вакцинтай хольж хэрэглэсний дараа дархлааны хариу урвал нэмэгдэж байгааг Аргентинд хийсэн судалгаа харуулжээ. Энэ тухай тус улсын Эрүүл мэндийн дэд сайд Даниел Ферранте мэдээлсэн байна. Аргентинд 600 гаруй хүнийг оролцуулсан гурван судалгаа хийжээ. Эдгээр судалгааны хүрээнд судлаачид "Спутник V" вакциныг Англи-Шведийн "AstraZeneca", Америкийн "Moderna" болон Хятадын "Sinopharm" компанийн

вакцинтай хольж туршсан байна. Судалгааг Оросын Шууд хөрөнгө оруулалтын сангийн дэмжлэгтэйгээр хийжээ. "Спутника V" болон "AstraZeneca" компанийн вакцины хослолыг Оросын вакцины хоёр тунг хийлгэсний дараах үр дүнтэй харьцуулахад дархлааны хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Харин "Спутник V"-ыг "Moderna"-гийн вакцинтай холиход дархлааны хариу урвал илүү хүчтэй байсан учир илүү их нөлөө үзүүлсэн байна. Харин "Спутник V"-ыг "Sinopharm"-ийн вакцинтай

хольж хийсэн туршилтын судалгааны үр дүнд хийж буй дүн шинжилгээ хараахан дуусаагүй байгаа аж.

Аргентин нь Орос, Беларусийн дараа "Спутник V" вакциныг хэрэглэж эхэлсэн дэлхийн гурав дахь улс. Тус улсын зохицуулагч байгууллага Оросын вакциныг хэрэглэх зөвшөөрлийг 2020 оны 12 дугаар сарын 23 -нд олгосон бөгөөд 12 дугаар сарын 29-нд эмнэлгийн ажилтнуудаа вакцинжуулж эхэлсэн байна.

Эх сурвалж: БУЭНОС-АЙРЕС. /TASS/